



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/102

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуулийн этгээд “Эм Ди роял трейдинг” ХХК (РД:6720854)-ын хүсэлтийг үндэслэн Мөрөн сумын 7 дугаар багт байршилтай Хиймарь-4, 457 тоот 6712008665 нэгж талбарын дугаартай 645м<sup>2</sup>, 7 дугаар багт байршилтай Хиймарь-4, 457б тоот 6712017383 нэгж талбарын дугаартай 1498м<sup>2</sup> үйлчилгээтэй орон сууцны зориулалттай 2 нэгж талбаруудын газруудыг нэгтгэж нийт 2143м<sup>2</sup> газрыг үлдсэн 23 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/688 тоот захирамжийн хавсралтын 3 дахь заалт, 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/40 дүгээр захирамжийн хавсралтын 8 дахь хэсгийг тус тус хүчингүй болгосугай.


3.Газар эзэмшиж байгаа хуулийн этгээд “Эм Ди роял трейдинг” ХХК (РД:6720854)-тэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзүл)-т тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-д үүрэг болгосугай

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6713010316  
Захирамж 2024